

**“ОВООТ ХЯР” НЭРТЭЙ XV-021670 ТООТ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН
ТАЛБАЙД ГИДРОГЕОЛОГИЙН ЦОГЦ СУДАЛГААНЫ АЖИЛ ХИЙЖ
ГҮЙЦЭТГЭХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ
ТСГ/2427**

Ажлын нэр төрөл	Тайлбар
Ажил гүйцэтгэх үндэслэл	“Эрдэнэс алт ресурс” ХХК-ийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших Овоот хяр нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайд ойр орчимд “Хойд бүргэд алт мөнгөний үндсэн ордын баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамж болон төслийн унд-ахуйн усан хангамжийн зориулалттай газрын доорх усны нөөц тогтоох.
Захиалагч байгууллага	“ЭРДЭНЭС АЛТ РЕСУРС” ХХК
Төслийн байршил, талбайн нэр	Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутагт орших “Овоот хяр” нэртэй хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн ойр орчимд буюу заасан талбайд
Талбайн хэмжээ	Гидрогеологийн эрэл-үнэлгээний судалгаа хийх талбайн хэмжээ 46390,00 га
Гэрээт ажлын зорилго	“Эрдэнэс алт ресурс” ХХК нь XV-021670 хайгуулын тусгай зөвшөөрлийн талбай дахь “Хойд бүргэд” алтны үндсэн ордын олборлолтын болон баяжуулах үйлдвэрийн хэвийн үйл ажиллагааг хангах.
Гүйцэтгэх ажил	<ul style="list-style-type: none"> ➢ Өмнөх судалгааны материалуудыг нэгтгэж дүгнэлт гаргах ➢ Хойд бүргэд алтны ордын гидрогеологийн судалгааг гүйцэтгэж уулын ажлын үед орж ирэх газар доорх урсцын хэмжээг тодорхойлсон байх, ус шүүрүүлэх, зайлуулах арга аргачлалын талаар зөвлөмж өгөх. ➢ Баяжуулах үйлдвэрийн технологийн усан хангамж болон төслийн унд-ахуйн усан хангамжийн зориулалттай газрын доорх усны эрэл-хайгуулын судалгааны ажлыг мөрдөж буй арга аргачлалын дагуу гидрогеологийн иж бүрэн судалгааг хийж баталгаат эх үүсвэрийг илрүүлэх. ➢ Технологийн болон унд-ахуйн усан хангамжийн эх үүсвэрийн газрын доорх усны ашиглалтын нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр үнэлж,

	<p>газрын доорх усны чанарын үнэлгээ өгч нөөцийн тооцоог батлагдсан аргачлалын дагуу тооцож судалгааны тайланг боловсруулах.</p> <p>Судалгааны шатанд гүйцэтгэх гидрогеологийн ажлын төрөл:</p> <p>Ордын гидрогеологийн судалгаа:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Геологи-гидрогеологийн маршрут, ажиглалт, уст цэгийн бүртгэл тооллого; ➤ Гадаргуугийн геофизикийн судалгааг хийх; ➤ Ордын гидрогеологийн нөхцөлийг нарийвчлан тогтоох зорилгоор гидрогеологийн цооногийг зохих технологийн дагуу төлөвлөх. ➤ Суурин боловсруулалт хийж ордын гидрогеологийн судалгааны тайланг боловсруулна; <p>Усан хангамжийн судалгаа:</p> <ul style="list-style-type: none"> ➤ Геологи-гидрогеологийн маршрут, ажиглалт, уст цэгийн бүртгэл тооллого. ➤ Төслийн талбайд хамгийн ойр талбайд гадаргуугийн геофизикийн судалгааг хийх. ➤ Гидрогеологийн эрлийн болон хайгуул ашиглалтын цооногийг технологийн дагуу төлөвлөх. ➤ Гидрогеологийн шавхалт туршилтын ажлыг аргачилсан зааврын дагуу гүйцэтгэж, үр дүнг боловсруулах. ➤ Судалгаа хийсэн талбайн хэмжээнд гидрогеологийн тайлан боловсруулан ашиглалтын нөөцийг тооцох. ➤ БОАЖЯ-ны Усны нөөцийн зөвлөлөөр хэлэлцүүлэн нөөц батлуулах. <p>Төсөл нь нийт технологийн усан хангамжид 10 л/с, унд ахуйн хэрэглээнд 5л/с- ээс багагүй хэмжээний ус ашиглана.</p>
Гэрээт ажлын үр дүн	<p>“Хойд бүргэд” алтны үндсэн ордыг ашиглах технологийн усны нөөцийг тодорхойлох, усны эх үүсвэр болон нөөцийг тогтоох.</p>
Ажлыг гүйцэтгэх хугацаа	<ul style="list-style-type: none"> ➤ Гүйцэтгэгч нь ажлыг гүйцэтгэх календарчилсан төлөвлөгөөг урьдчилсан байдлаар бэлтгэж захиалагчид танилцуулна. ➤ Захиалагчийн зөвшөөрч баталсан календарчилсан төлөвлөгөөний дагуу ажлыг гүйцэтгэх

<p align="center">Ажил гүйцэтгэхэд шаардлагатай хүний нөөц</p>	<ol style="list-style-type: none"> 1. Төслийн удирдагч – 1 хүн Мэргэшсэн болон зөвлөх гидрогеологич зэрэгтэй байх Мэргэжлээрээ 10-аас дээш жил ажилласан ба төсөл удирдаж байсан туршагатай байх Үндсэн ажилтан байна 2. Гидрогеологич – 1 хүн Гидрогеологич мэргэжилтэй байх, Мэргэжлээрээ 5-аас дээш жил ажилласан туршагатай байх Үндсэн ажилтан байна 3. Өрмийн мастер – 1 хүн Өрмийн инженер мэргэжилтэй байх 2 ба түүнээс дээш жил мэргэжлээрээ ажилласан туршлагатай байх Гэрээт ажилтан байж болно 4. Өрмийн туслах – 4 хүн Өмнө өрмийн туслах хийж байсан туршлагатай байх
<p align="center">Ажил гүйцэтгэхэд шаардлагатай тоног, төхөөрөмж</p>	<ol style="list-style-type: none"> 1. Усны өрмийн машин - 1 ш /Усны өрмийн машин нь 96-210 мм өрмийн хошуутай байх, 300 метр хүртэл өрөмдөх хүчин чадалтай байх/ 2. Түлшний машин – 1 ш /5тн багтаамжтай түлш түгээх зориулалтын авто машин/ 3. Компрессор /Шавхалт хийх/ - 1 ш
<p align="center">Хээрийн ажлын бэлтгэл:</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Өмнөх он жилүүдэд Хармагтай зэс-алтны ордын болон ойролцоо талбайд хийгдсэн геологи-гидрогеологийн судалгааны ажлын үр дүнгийн тайлангийн хэвлэмэл болон архивын баримт материалуудыг судлах, танилцуулах. ➤ Сансрын ба байр зүйн зургийг ашиглан хээрийн тандан судалгааны маршрутыг тогтоох. ➤ Хээрийн ажлын багийг зохион байгуулж, гидрогеологийн ажлын бэлэн байдлыг хангана.
<p align="center">Хээрийн судалгааны үе шат:</p>	<p>Энэ шатанд дараах ажлуудыг гүйцэтгэнэ.</p> <ul style="list-style-type: none"> ➤ Монгол Улсын Засгийн Газрын Хэрэгжүүлэгч Агентлаг УСНЫ ГАЗАР 2022.06.06 01/654 дугаартай албан бичгийн дагуу гидрогеологийн судалгааны ажлыг явуулах.

	<ul style="list-style-type: none"> ➤ Геологи-гидрогеологийн маршрутын судалгаагаар ордын талбайн геоморфологи, геологийн тогтоц, газар доорх усны тэжээгдэл, зөөгдөл, хөлийн бүсүүдийг тодорхойлох, талбайд илэрсэн уст цэгүүдийг бүртгэх, гадаргуугийн геофизикийн судалгааг хийх байрлалыг тодорхойлох. ➤ Талбайн геофизикийн ажлыг хэтийн төлөв бүхий талбайн хэмжээнд хийх. ➤ Усжилт өндөртэй байх цэгүүдийг тогтоож гидрогеологийн цооног төлөвлөх. ➤ Гидрогеологийн шавхалт туршилтын ажлыг зохих зааврын дагуу хийх ба туршилтын шавхалтыг 72 цагаас доошгүй хийх ➤ Гидрогеохимийн сорьцлолтын ажлыг гүйцэтгэж, Газрын доорх усны шинжилгээг итгэмжлэгдсэн лабораториор шинжлүүлж баталгаажуулсан байх. ➤ Топо-геодезийн ажлаар цооногуудын болон зарим уст цэгүүдийн өндрийн ба талбайн холболтыг хийнэ. ➤ Судалгааны ажлын дараа хайгуулын цооногийг битүүмжлэн хаах, эсвэл ашиглалт, ажиглалтын цооног болгон тоноглоно. ➤ Баримт материалын зургийг баяжуулан зурж, зохих холболтуудыг хийх.
<p style="text-align: center;">Тайлагнах, хяналт шалгалт</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Хээрийн судалгааны ажлын явцад хээрийн суурин боловсруулалт хийнэ. ➤ Суурин боловсруулалтын төгсгөлийн ажлаар хээрийн судалгааны материалыг гүйцээж боловсруулна. Үүнд: <ul style="list-style-type: none"> • Тулгуур мэдээллийг иж бүрэн боловсруулна. • Гидрогеологийн зураг болон зүсэлт зургуудыг зохих хураангуйллаар зохиож хэвлэж бэлтгэнэ. • Газрын доорх усны гидроизогипсийн зураг зохиож, тархалтын ба тэжээгдлийн мужийг тодорхойлно. • Газрын доорх усны ашиглалтын нөөцийг тооцож, холбогдох төрийн байгууллагаар батлуулах.
<p>Төлбөр тооцоо</p>	<ul style="list-style-type: none"> ➤ Гэрээнд заасны дагуу төлбөрийг хийнэ.

Даалгаварт тусгагдаагүй ажил	➤ Даалгаварт тусгагдаагүй ажлыг нэмэлт нөхцөлөөр гүйцэтгэнэ.
---	--

2024 онд гидрогеологийн эрэл-үнэлгээний судалгааны ажил хийх талбайн зураг

